8 дугаар бүлэгт дурдсан
7 дугаар хавсралт

Хувь хүний шилжилт хөдөлгөөний талаарх
тусгай үүрэг амлалт

(1 дэх хэсэг нь япон, англи хэлээр байх ба
энэхүү хавсралтын салшгүй хэсэг болно)

2 дахь хэсэг
Монгол Улсын Тусгай үүрэг амлалт

Монгол Улс нь энэхүү хэсгийн заалт тус бүрт тусгасан нөхцөл, шаардлагын дагуу хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл хүсч буй Япон Улсын хувь хүнийг хилээр нэвтрэхээс өмнө зохих виз авахыг шаардаж болно.

1 дүгээр заалт
Япон Улсын богино хугацаагаар зорчих бизнес эрхлэгчид

Монгол Улсад бараа, эсхүл үйлчилгээ худалдан борлуулахтай холбоотой хэлэлцээ хийх, эсхүл Монгол Улсад хөрөнгө оруулах бэлтгэл ажлыг хангах, эсхүл түүнтэй төстэй үйл ажиллагаа явуулах зэрэг бизнесийн харилцаанд оролцох зорилгоор цалин урамшуулал авахгүй, нийтэд шууд борлуулалт хийх, эсхүл өөрөө үйлчилгээ үзүүлэхгүйгээр Монгол Улсад зорчих Япон Улсын хувь хүнд 30 хоногоос илүүгүй хугацаагаар хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгох бөгөөд уг хугацааг сунгаж болно.

2 дугаар заалт
Япон Улсын корпорацийн дотор шилжин ажиллагсад

1. Япон Улсын хуулийн этгээдийн Монгол Улс дахь арилжааны төлөөлөлд үйл ажиллагааны хугацаанаас хамааруулан менежер, захирал, эсхүл мэргэшсэн ажилтан болохоор тус арилжааны төлөөллийн газар шилжин ирж буй Япон Улсын хувь хүнд нэг жилийн хугацаанд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгох бөгөөд уг хугацааг сунгаж болно.

2. “Менежер” гэх нэр томьёо нь тухайн байгууллагыг голлон удирддаг, эсхүл байгууллагын газар, эсхүл хэлтсийг удирддаг, эсхүл бусад хяналт, мэргэжлийн болон удирдах албан тушаалтны ажлыг хянан зохион байгуулдаг тухайн байгууллагын хувь хүнийг хэлнэ. Уг хувь хүн нь ажилд авах, халах, эсхүл дэвшүүлэх буюу чөлөө олгох зэрэг боловсон хүчний бусад арга хэмжээ авах эрх мэдэлтэй бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг бүрэн эрхтэйгээр удирдан явуулдаг байна. “Менежер” гэдэгт удирдлаган дор ажиллаж буй ажилтан нь мэргэжлийн ажилтан байхаас бусад тохиолдолд анхан шатны зааварлагч, мөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эсхүл үйлчилгээ явуулахад шаардлагатай чиг үүргийг гүйцэтгэдэг ажилтан хамаарахгүй.

3. “Захирал” гэх нэр томьёо нь байгууллагын үйл ажиллагааг шууд удирдаж, өргөн цар хүрээтэй шийдвэр гаргадаг бөгөөд зөвхөн дээд шатны захирал, захирлуудын зөвлөл, эсхүл бизнесийн хувьцаа эзэмшигчээс чиглэл, эсхүл удирдамж авдаг байгууллагын доторх хувь хүнийг хэлнэ. “Захирал” нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эсхүл үйлчилгээ явуулах чиг үүргийг шууд хэрэгжүүлэхгүй.

4. “Мэргэшсэн ажилтан” гэх нэр томьёо нь мэргэшлийн дээд түвшний мэдлэгтэй бөгөөд байгууллагын үйлчилгээ, судалгааны хэрэгсэл, арга барил эсхүл менежментийн чухал мэдлэгийг эзэмшдэг байгууллагын доторх хувь хүнийг хэлнэ. “Мэргэшсэн ажилтан”-д тусгай зөвшөөрөл бүхий мэргэжил эзэмшсэн хүмүүс багтах боловч зөвхөн түүгээр хязгаарлагдахгүй.

3 дугаар заалт
Япон Улсын хөрөнгө оруулагч

Монгол Улсад түр оршин суух хугацаандаа Монгол Улсын хууль тогтоомжоор зөвшөөрсөн дараахь үйл ажиллагааны аль нэгийг эрхлэх Япон Улсын хувь хүнд нэг жилийн хугацаанд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрлийг олгох бөгөөд уг хугацааг сунгаж болно:

(a) Монгол Улс дахь бизнестээ хөрөнгө оруулалт хийх, тухайн бизнесийг удирдах үйл ажиллагаа;

(b) Монгол Улс дахь бизнест хөрөнгө оруулсан Монгол Улсаас бусад улсын этгээдийг төлөөлөн тухайн бизнесийг удирдах үйл ажиллагаа;

(c) Монгол Улсаас бусад улсын этгээдийн хөрөнгө оруулалттай бизнесийг Монгол Улсад эрхлэх.

4 дүгээр заалт
Япон Улсын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч хувь хүн

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэргэшсэн үйлчилгээ үзүүлэгч Япон Улсын хувь хүнд нэг жилийн хугацаанд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгох бөгөөд уг хугацааг сунгаж болно.

5 дугаар заалт
Монгол Улс дахь төрийн, эсхүл хувийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр өндөр түвшний технологи, эсхүл мэдлэг шаарддаг үйлчилгээ үзүүлэх Япон Улсын хувь хүн

1. Монгол Улс дахь төрийн, эсхүл хувийн байгууллага болон Япон Улсын хувь хүн хоорондын байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээ

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улс дахь төрийн, эсхүл хувийн байгууллагатай тухайн хувь хүний байгуулсан гэрээг үндэслэн техникийн, зөвлөхийн, эсхүл удирдах чиг үүрэг бүхий албан тушаал эрхэлдэг Япон Улсын хувь хүнд нэг жилийн хугацаанд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгох бөгөөд уг хугацааг сунгаж болно.

2. Япон Улсын хуулийн этгээд болон Монгол Улсын хуулийн этгээд хооронд байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээ

Монгол Улсад арилжааны оролцоогүй Япон Улсын хуулийн этгээдийн ажилтан нь Монгол Улсад 90 хоног, эсхүл (а) дэд хэсэгт дурдсан төрийн, эсхүл хувийн байгууллагатай байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хугацааны аль богино хугацаанд хилээр нэвтэрч, түр оршин сууж болох бөгөөд үүнд дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

(a) Япон Улсын хуулийн этгээд нь Монголд үйлчилгээний ажил эрхэлж буй Монгол Улсын хуулийн этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Монгол Улсын эрх бүхий байгууллага нь энэхүү хэсгийн дагуу хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгохдоо тухайн гэрээний хүчин төгөлдөр байдлыг батлах шаардлагатай арга хэмжээг авч болно;

(b) Хувь хүн нь дараахь нөхцөлийг хангасан байна:

(i) их дээд сургуулийн зэрэг, эсхүл түүнтэй дүйцэх түвшний мэдлэгийг нотлох баримт бичигтэй байх;

(ii) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тухайн салбарт үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн боловсрол эзэмшсэн байх.

(c) Тухайн хувь хүн нь Монгол Улсад арилжааны төлөөлөлгүй Япон Улсын хуулийн этгээдэд багадаа нэг жил ажилласан байна.

6 дугаар заалт
Дагалдан яваа эхнэр, эсхүл нөхөр ба хүүхэд

2-оос 5 дугаар заалтад заасны дагуу хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл бүхий Япон Улсын хувь хүнийг дагалдан яваа эхнэр, эсхүл нөхөр ба хүүхдэд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгоно.